



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төгрөг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/11/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Алтай хот	Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a>
2024 он	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: М.Атарцэцэг
	Утас: 88984411 Цахим хаяг: <a href="mailto:atartsetsegm@audit.gov.mn">atartsetsegm@audit.gov.mn</a>
	Аудитор: Б.Мөнхболд
	Утас: 99041008 Цахим хаяг: <a href="mailto:munkhboldbo@audit.gov.mn">munkhboldbo@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТӨГРӨГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.ЧИМЭГБАЯР ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024. 03. 25 № 134

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төгрөг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төгрөг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг хүргүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны зардлын нийт гүйцэтгэл өмнөх оноос 675.5 сая төгрөг буюу 34.8 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгосонтой холбоотой байна

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд 5 хөтөлбөр 17 зорилт 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 82.0 хувиар дүгнэсэн байна

0702900259

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	552,111.8	686,221.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,425,687.9	1,597,842.1
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,977,799.7</b>	<b>2,284,063.2</b>
Нийт өр төлбөрийн дүн	7,765.0	76,323.2
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,970,034.7	2,207,740.1
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,977,799.7</b>	<b>2,284,063.2</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,337,585.8	1,612,100.0
Үйл ажиллагааны зардлын дүн	1,683,261.1	1,268,872.2
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>654,324.7</b>	<b>343,227.8</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	3,320,414.4	80,022.4
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(2,666,089.7)</b>	<b>263,205.4</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,636,124.4	1,944,534.7
Тайлант оны үр дүн	(2,666,089.7)	263,205.4
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,970,034.7</b>	<b>2,207,740.1</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,932,521.5	1,494,416.1
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,616,918.8	1,108,435.7
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>315,602.7</b>	<b>385,980.4</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(359,248.5)</b>	<b>(236,878.1)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>(71,000.0)</b>	<b>(5,000.0)</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(114,645.9)</b>	<b>144,102.3</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	266,653.4	152,007.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	152,007.5	296,109.9
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ, ОНТ</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,386,831.9</b>	<b>1,197,672.0</b>
Урсгал зардал	1,068,389.3	1,011,694.5
Хөрөнгийн зардал	240,102.6	180,977.4
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	78,340.0	5,000.0
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,386,831.9</b>	<b>1,280,924.1</b>
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,257,131.9</b>	<b>1,192,231.3</b>
Орон нутгийн төсвөөс	1,096,979.8	1,036,883.8
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	160,152.1	155,347.5
<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	<b>129,700.0</b>	<b>88,692.7</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	266,653.4	152,007.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	152,007.5	296,109.9

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 24,259.0 мянган төгрөгийн 4 алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 26,300.2 мянган төгрөгийн 8 зөрчил илрүүлснээс, 4,779.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21,520.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй зөрчлийн дүн 26,300.2 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 27,736.6 мянган төгрөгөөс бага тул "Зөрчилгүй" дүгнэлт өглөө.

### 5.1.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

### 5.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг 1,365.1 мянган төгрөгийн 2 алдааг илрүүлж, аудитын явцад залруулж, 15,291.2 мянган төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс 4,455.5 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,835.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж хүргүүлсэн байна.

### 5.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг 23,163.9 мянган төгрөгийн 2 алдааг илрүүлж, аудитын явцад залруулж, 9,655.8 мянган төгрөгийн 2 зөрчил илрүүлж, 324.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 9,331.4 мянган төгрөгийн 1 зөрчилд зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

## 5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 26,300.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн байна.

### 5.2.1 Албан шаардлага

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд малын тоо толгойн албан татвар 1,353.2 мянган төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон

нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 24,947.0 мянган төгрөгийн төгрөгийн 5 зөрчил илэрч 4,779.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 20,167.0 мянган төгрөгийн 3 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасныг зөрчсөн эрх ба үүрэг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

**6.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар	2	23,163.9	-	-	2	23,163.9	2	23,163.9	-	-
Төгрөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	865.1	1	865.1	1	865.1	1	865.1	-	-
Төгрөг сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	500.0	-	-	1	500.0	1	500.0	-	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>24,529.0</b>	<b>1</b>	<b>865.1</b>	<b>4</b>	<b>24,529.0</b>	<b>4</b>	<b>24,529.0</b>	<b>-</b>	<b>-</b>



6.2 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалта	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс түгээрт	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
						Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
								Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төгрөг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1	-	-	-	2	1,353.2	-	2	1,353.2	-	-	
Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар	1	1	-	-	-	2	9,655.8	1	324.4	1	9,331.4	-	
Төгрөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	-	-	1	1	1,275.6	-	-	1	1,275.6	-	
Төгрөг сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	1	1	4,455.5	1	4,455.5	-	-	-	
Төгрөг сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	1	1	9,560.1	-	-	1	9,560.1	-	
Төгрөг сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>8</b>	<b>26,300.2</b>	<b>2</b>	<b>4,779.9</b>	<b>6</b>	<b>21,520.3</b>	<b>0</b>	

6.3 Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар	1	19,000.0	-	-	1	19,000.0	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>19,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>19,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>